

I. 6 Чех хэлний мэдлэггүй сурагчдын хууль ёсны төлөөлөгчдөд дамжуулах мэдээлэл.  
(<https://cizinci.npi.cz> хаягаар гадаад хэл дээрх хувилбараар авах боломжтой)

## ХҮҮХДҮҮДЭЭ СУРГУУЛЬД ДАСАЖ НЭГДЭХИЙГ НЬ ХЯЛБАР БОЛГОНО УУ

### 1. Хувийн мэдээлүүд

Анхны ярилцлагын үеэр сургуульд өөрийнхөө болон хүүхдийнхээ талаар аль болох их мэдээлэл өгнө үү. Мэдээлэл нь зөвхөн сургуулийн хэрэгцээнд зориулагдсан тул бусад хүмүүст өгөхгүй. Эдгээр нь багш нар таны хүүхэдтэй холбоо тогтоож, түүнийг илүү сайн ойлгож, боловсролд нь туслах болно.

#### Сургуульд дараахи мэдээллийг өгнө үү:

Таны хүүхдийн нэрийг яаж бичдэг болон дууддаг вэ, гэртээ хэн гэж дууддаг вэ.

Ямар улсаас ирсэн вэ

БНЧУлсад оршин суух хэлбэр

БНЧУлсад оршин суух шалтгаан

Сургуультай холбоо барих хүний хаяг ба утасны дугаар, харилцах арга

БНЧУлс дахь таны ажил

Таны хүүхдийн боловсролын одоог хүртлэх байдал

Таны хүүхдийн боловсролд нөлөөлөх орчин нөхцөл (авьяас, хязгаарлалт)

Эрүүл мэндийн байдал

Хооллох зуршил

Хобби ба сонирхдог зүйлс

### 2. Сургуультай танилцсан тухай

Та хүүхэдтэйгээ шинэ сургуулийн талаар ярилцаарай. Түүний мэдрэмж - айдас, түгшүүрийг анзаарч ажиглаарай.

Та хүүхэдтэйгээ сургуулиар хамт явж, сургуулиас өгсөн бүх материалуудыг түүнтэй хамт үзээрэй.

### 3. "Хөтөч" -ийн тусlamж

Олон сургуульд шинээр ирсэн хүмүүст "хөтөч" гэж нэрлэгддэг хүмүүс тусалдаг. Таны хүүхдэд хичээл, завсарлагааны үеэр анхаарал тавьж, халамжлах ангийн хүүхэд хуваарилагдана. Хүүхдээсээ хэн нэгэн түүнд тусалж байгаа эсэх болон түүний нэрийг нь хэн болохыг асуугаарай.

### 4. Сургуультай харилцах

Хэрэв та өөрийнхөө чех хэлэнд эргэлзэж байгаа бол сургуулийн зүгээс орчуулагч зохицуулж болох эсэхийг нь лавлаарай, эсвэл анх үүлзахдаа өөрийн орчуулагчийг дагуулж ирнэ үү.

Багштай хэрхэн харилцах арга хэлбэрийн талаар тохиролцож, шаардлага гарсан тохиолдолд хандаж болох хүмүүстэй холбоо барих хүмүүсийн нэр, утасны дугаарыг авна үү. Ойлгомжгүй юмуу тодруулах зүйл гарах болгонд сургуультай холбогдож байгаарай. Таны оролцоо хүүхдийн тань боловсролд маш чухал юм.

### 5. Таньд бүх мэдээлэл байна үү????

Сургууль таниас ямар хамтын ажиллагаа шаарддаг болохыг та мэдэх үү? Та сургуулийн ба ангийн дүрмийг мэдэх үү? Хүүхэд сургуульдаа ирж чадахгүй болвол яаж, хэзээ, хэнд дуулгаж хичээллээс нь чөлөө авахыг мэдэх үү? Хүүхдийнхээ боловсролд нь хэрхэн тусалж болох талаар хангалттай мэдээллэл таньд бий юу? Үнэлж дүн тавих тухай системийг та ойлгож байна үү? Таны хүүхдэд хэрэгтэй туслах хэрэгслийн жагсаалт байгаа үү? Сургуулийн гуанз, өдөр өнжүүлэх анги, хичээллээс гадуурх үйл ажиллагаанууд хэрхэн явагддагийг та мэдэх үү? Сургуультай харилцах ямар онлайн систем ашигладгийг та мэдэх үү? Гэрийн даалгаврыг хэрхэн яаж явуулдаг, хүлээлгэж өгдөгийг та мэдэх үү? **Хэрэв мэддэггүй бол сургуулиас асуухаас бүү айгаарай, таны хүүхдэд хэрэгтэй юм шүү.**

## 6. Хүүхэдтэйгээ ярилцаарай

Шинэ орчинд дасан зохицох, шинэ хэл сурах нь хүүхэд бүрт түйлын хэцүү байдаг. Таны хүүхдэд таны дэмжлэг маш их хэрэгтэй. Хэрэв таны хүүхэд өөрийн орны сургуульд сурч, онцсайн дүн авдаг байсан бол чех сургуульд явахдаа эхний саруудад урам нь хугарч, амжилтгүй, бүтэлгүйтэх мэдрэмж төрж магадгүй юм. Чех хэлийг хоёрдахь хэлээ болгон сурч байгаа томдуу хүүхдүүдэд ийм мэдрэмж төрөх нь хэвийн үзэгдэл юм. Тэдэнд хугацаа олгоорой, бүү яараарай харин дэмжээрэй. Тэдний чадварт итгэдэг гэдгээ тэдэнд харуулна уу. Тэвчээртэй байгаарай.

Чех хэл дээр харилцааны анхан шатны үр чадварыг хөгжүүлэхэд нэг жил, зохион бичлэг амжилттай бичихэд 7 жил хүртэл хугацаа шаардагдана. Хэрэв сургууль нь сурган хүмүүжүүлэх-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төвд зөвлөгөө өгөхийг санал болговол хамтарч ажиллана үү. Энэ бол таны хүүхэд бөгөөд сургууль түүнд туслахыг хичээдэг. Тэрээр таны хүүхэд илүү сайн суралцаж үр дүнд хүрэхийн тулд дэмжлэг үзүүлэхийг хүсдэг.